



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/208-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
СС	Сангийн сайд
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

САЙХАН СУМЫН ГУРАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.ҮҮРЦАЙХ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/208-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг нь 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 87.9 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Тус байгууллага нь хүүхдийн хоолны зардлыг 4,437.0 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 107,253.9 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн зардлыг 26,008.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсвийг 12.1 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар

тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 13 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,601,961.94	201,343,128.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,554,823.00	137,769,101.06
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,554,823.00	137,769,101.06
31210	Төгрөг	18,554,823.00	137,769,101.06
31211	Төрийн сангийн харилцах	18,554,823.00	137,769,101.06
33	АВЛАГА	1,144,612.00	-
33500	Бусад авлага	1,144,612.00	-
33510	Байгууллагаас авах авлага	1,144,612.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	58,902,526.94	63,574,026.94
35400	Хангамжийн материал	58,902,526.94	63,574,026.94
35470	Бусад хангамжийн материал	58,902,526.94	63,574,026.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	387,707,044.96	349,584,376.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	387,707,044.96	349,584,376.65
39200	Биет хөрөнгө	365,912,220.07	328,102,051.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	503,710,170.02	503,710,170.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(171,098,219.36)	(204,359,414.36)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	48,516,022.00	51,871,172.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,226,971.89)	(35,449,212.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,251,572.14	25,368,052.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,211,246.16)	(17,482,207.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,956,845.58	5,956,845.58
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,302,043.20)	(3,829,444.52)
39217	Ном	2,316,090.94	2,316,090.94
39300	Биет бус хөрөнгө	21,794,824.89	21,482,324.85
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(859,375.11)	(1,171,875.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,404,200.00	21,404,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	466,309,006.90	550,927,504.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	48,874,200.89	14,979,836.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	48,874,200.89	14,979,836.22
41300	Өглөг	48,874,200.89	14,979,836.22
41360	Бусад өглөг	48,874,200.89	14,979,836.22
41361	Байгууллагад төлөх өглөг	48,874,200.89	14,979,836.22
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	417,434,806.01	535,947,668.43
51	Засгийн газрын хувь оролцоо	417,434,806.01	535,947,668.43
51100	Засгийн газрын оруулсан капитал	533,912,670.00	533,912,670.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	533,912,670.00	533,912,670.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(549,777,174.32)	(431,264,311.90)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,020,801,246.43)	(549,777,174.32)
51220	Тайлант үеийн үр дүн	471,024,072.11	118,512,862.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	433,299,310.33	433,299,310.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	466,309,006.90	550,927,504.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,368,653,082.73	1,144,777,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	489,344,924.73	26,190,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	489,344,924.73	26,190,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	432,312,115.31	2,497,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	56,962,809.42	23,623,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	879,308,158.00	1,118,587,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	649,520,200.00	864,345,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	649,520,200.00	864,345,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	229,787,958.00	254,241,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	229,787,958.00	254,241,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	897,629,010.62	1,026,264,537.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	897,629,010.62	1,026,264,537.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888,542,510.62	1,026,264,537.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,655,758.00	571,689,057.21
210101	Үндсэн цалин	337,886,821.00	394,656,290.21
210102	Нэмэгдэл	108,484,860.00	160,405,286.00
210104	Урамшуулал	12,967,800.00	16,627,481.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,316,277.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,529,613.00	72,683,824.00
210201	Тэтгэврийн даатгал	41,404,566.00	48,728,498.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,809,103.00	6,253,981.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,852,118.00	3,999,765.00
210204	Ажилгүйдлийн даатгал	949,971.00	1,252,333.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,513,855.00	12,449,247.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,023,134.79	209,376,535.33
210301	Гэрэл, цахилгаан	9,660,134.00	10,419,715.80
210302	Түлш, халаалт	181,478,787.79	187,363,963.53
210303	Цэвэр, бохир ус	8,884,213.00	11,592,856.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,221,691.48	-
210408	Бараа материал акталсны зардал	1,221,691.48	-
2105	Нормативт зардал	75,611,570.00	75,539,130.00
210502	Хоол, хүнс	75,611,570.00	75,539,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	5,970,500.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	5,970,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,347,482.00	1,418,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,347,482.00	1,418,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,153,261.35	89,586,891.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,748,291.00	39,711,422.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,400,000.00	4,255,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,004,970.35	45,619,668.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,086,500.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,086,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,086,500.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	471,024,072.11	118,512,862.42
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	471,024,072.11	118,512,862.42

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	879,378,158.00	1,118,657,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	879,308,158.00	1,118,587,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	649,520,200.00	864,345,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	649,520,200.00	864,345,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	229,787,958.00	254,241,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	229,787,958.00	254,241,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	858,423,435.00	994,442,921.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	858,423,435.00	994,442,921.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	849,336,935.00	994,442,921.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,800,370.00	570,544,445.21
210101	Үндсэн цалин	339,031,433.00	393,511,678.21
210102	Нэмэгдэл	108,484,860.00	160,405,286.00
210104	Урамшуулал	12,967,800.00	16,627,481.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,316,277.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,529,613.00	72,683,824.00
210201	Тэтгэврийн даатгал	41,404,566.00	48,728,498.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,809,103.00	6,253,981.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,852,118.00	3,999,765.00
210204	Ажилгүйдлийн даатгал	949,971.00	1,252,333.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,513,855.00	12,449,247.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,738,200.00	243,270,900.00
210301	Гэрэл, цахилгаан	9,660,134.00	10,419,715.80
210302	Түлш, халаалт	186,193,853.00	221,258,328.20
210303	Цэвэр, бохир ус	8,884,213.00	11,592,856.00
2105	Нормативт зардал	75,611,570.00	75,539,130.00
210502	Хоол, хүнс	75,611,570.00	75,539,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	5,970,500.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	5,970,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,347,482.00	1,418,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,347,482.00	1,418,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,309,700.00	25,015,522.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,909,700.00	20,759,722.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,400,000.00	4,255,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,086,500.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,086,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,086,500.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,954,723.00	124,214,278.06
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,399,900.00	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,399,900.00	5,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,399,900.00	5,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,399,900.00	5,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,399,900.00)	(5,000,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	18,554,823.00	119,214,278.06
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,554,823.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,554,823.00	137,769,101.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	533,912,670.00	433,299,310.33	(1,020,801,246.43)	(53,589,266.10)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(1,020,801,246.43)	(53,589,266.10)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	471,024,072.11	471,024,072.11
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(549,777,174.32)	417,434,806.01
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(549,777,174.32)	417,434,806.01
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(549,777,174.32)	417,434,806.01
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	118,512,862.42	118,512,862.42
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(431,264,311.90)	535,947,668.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,137,142,000.00	999,442,921.94	137,699,078.06	87.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,137,142,000.00	999,442,921.94	137,699,078.06	87.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,137,142,000.00	999,442,921.94	137,699,078.06	87.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,362,800.00	570,544,445.21	105,818,354.79	84.4
210101	Үндсэн цалин	462,376,000.00	393,511,678.21	68,864,321.79	85.1
210102	Нэмэгдэл	192,919,300.00	160,405,286.00	32,514,014.00	83.1
210104	Урамшуулал	21,067,500.00	16,627,481.00	4,440,019.00	78.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,114,100.00	72,683,824.00	27,430,276.00	72.6
210201	Тэтгэврийн даатгал	68,216,500.00	48,728,498.00	19,488,002.00	71.4
210202	Тэтгэмжийн даатгал	7,974,500.00	6,253,981.00	1,720,519.00	78.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,379,400.00	3,999,765.00	2,379,635.00	62.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,595,100.00	1,252,333.00	342,767.00	78.5
210205	Эрүүл мэндийн даатгал	15,948,600.00	12,449,247.00	3,499,353.00	78.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	243,270,900.00	243,270,900.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	14,308,500.00	10,419,715.80	3,888,784.20	72.8
210302	Түлш, халаалт	216,016,700.00	221,258,328.20	(5,241,628.20)	102.4
210303	Цэвэр, бохир ус	12,945,700.00	11,592,856.00	1,352,844.00	89.5
2105	Нормативт зардал	79,976,100.00	75,539,130.00	4,436,970.00	94.5
210502	Хоол, хүнс	79,976,100.00	75,539,130.00	4,436,970.00	94.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,970,500.00	10,970,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,970,500.00	10,970,500.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,418,600.00	1,418,600.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,418,600.00	1,418,600.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,029,000.00	25,015,522.73	13,477.27	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,773,100.00	20,759,722.73	13,377.27	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,255,900.00	4,255,800.00	100.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,137,142,000.00	1,118,657,200.00	18,484,800.00	98.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	864,345,800.00	864,345,800.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	864,345,800.00	864,345,800.00	-	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	254,241,400.00	254,241,400.00	-	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	254,241,400.00	254,241,400.00	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,554,800.00	70,000.00	18,484,800.00	0.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00	(70,000.00)	-
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	18,554,800.00	-	18,554,800.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,554,823.00	(18,554,823.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	137,769,101.06	(137,769,101.06)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилсан менежментийг сайжруулж, хүүхэд бүрийн онцлогт нийцүүлэн сурах, хөгжих арга барилыг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, иргэдэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэх
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдалд, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах, үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж сурлагын амжилтад ахиц гаргах
- Багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системийг ашиглан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт ахиц, үр дүнг тооцох, ажлын байранд түшиглэсэн багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгох
- Онцгой байдлын үед хүүхэд өөрийгөө болон бусдыг хамгаалах, мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлэх дадлага сургуулилтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж аливаа гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг хөгжүүлэх
- Цэцэрлэгийн номын сангийн орчинг сурах, сургах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүүхдийн сурч хөгжих, төлөвших, хамтран ажиллах, мэдээлэл авахад нь туслах орчин болгон өөрчилж, үйлчилгээний нээлттэй байдлыг хангах Суралцагчдыг цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд батлагдсан,*
- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,618.5 мянган төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,554.8	137,769.1	119,214.3
Авлага	1,144.7	-	(1,144.7)
Бараа материал	58,902.5	63,574.0	4,671.5
Үндсэн хөрөнгө	387,707.0	349,584.4	(38,122.6)
Нийт хөрөнгө	466,309.0	550,927.5	84,618.5
Өр төлбөр	48,874.2	14,979.8	(33,894.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	417,434.8	535,947.7	118,512.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	466,309.0	550,927.5	84,618.5

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 137,769.1 мянган төгрөг болж 119,214.3 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 63,574.0 мянган төгрөг болж 4,671.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 97,433.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, эцэг эхчүүдээс 22,535.2 мянган төгрөгийн сургалт, эрүүл ахуйн хэрэглэгдэхүүн, 1,088.0 мянган төгрөгийн зөөлөн эдлэлийг үнэ төлбөргүйгээр хандив тусламжаар хүлээн авч, үйл ажиллагаанд 116,385.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 349,584.4 мянган төгрөг болж 38,122.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 5,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, ажилчдын хандиваар 2,497.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч Сайхан сумын ИТХ-ын

2023 оны 12-р сарын 20-ны өдрийн 34 дүгээр тогтоолын дагуу 6,025.4 мянган төгрөгийн ашиглах боломжгүй болсон хөрөнгийг данснаас хасаж бүртгэснээс,
4. Өр төлбөр дансны үлдэгдэл 14,979.8 мянган төгрөг болж 33,894.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны түлш, халаалтын өрийг тайлант онд барагдуулснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 810,439.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 244,962.5 мянган төгрөг нийт 1,055,402.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 219,198.7 мянган төгрөгөөр бууруулж 591,240.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 249,241.4 мянган төгрөгөөр, нийт 840,482.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 291,659.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 882,900.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 254,241.4 мянган төгрөгөөр нийт 1,137,142.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 882,900.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 254,241.4 мянган төгрөг, нийт 1,137,142.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 999,442.9 мянган төгрөгийг зарцуулж, 137,699.1 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 999,442.9 мянган төгрөг буюу 87.9 хувьтай байгаа нь хүүхдийн хоолны зардлыг 4,437.0 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 107,253.9 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн зардлыг 26,008.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	882,900.6	745,201.5	137,699.1	84.4
81605 - Эрүүл мэндийг дэмжих	2,128.0	2,128.0	-	100
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	79,976.1	75,539.1	4,437.0	94.45
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4,368.5	4,368.5	-	100
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	2,128.0	2,128.0	-	100
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	628,227.0	520,973.1	107,253.9	82.93
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	166,073.0	140,064.8	26,008.2	84.34
Орон нутгийн төсвөөс санхүүжих	254,241.4	254,241.4	-	100
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	254,241.4	254,241.4	-	100
ДҮН	1,137,142.0	999,442.9	137,699.1	87.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад “Арцат алтайн Уулс” ХХК, Ханангийн хөх бууц ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран 2023 оны 04 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2023 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 897,629.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,464.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 23/57 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,109.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс ХХОАТ-ын тооцооллыг буруу хийснээс ХХОАТ-ын авлага үүсгэсэн зөрчилд 1 албан шаардлага, төсөвт тусгагдаагүй зардал гаргаж илүү цагийн хөлсийг нэмэгдүүлэн олгосон зөрчилд 1 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	1,144.60	1	1,144.60	100.0
Зөвлөмж	1	4,965.00	1	4,965.00	100.0
Нийт дүн	2	6,109.60	2	6,109.60	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт "2022 оны санхүүгийн тайланд **"Зөрчилгүй", "Итгэл үзүүлсэн", "Түүвэрт хамрагдсан"** гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно" гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **1,114.0** мянган төгрөгийн урамшууллыг нягтлан бодогч О.Буяндүүрэнд давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.3 : "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **754.8** мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 754.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Шалгуур үзүүлэлтийг харгалзалгүйгээр багш нарт тус бүр 15.0 - 25.0 хувиар тооцон, нийт 754.8 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдлийг илүү бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно.” “цэцэрлэгийн түвшинд амжилт гаргасан 10%” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:* Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй газрын гэрчилгээг шинэчлэн бүртгүүлээгүй, Э дугаартай улсын дугаар аваагүй байна. Энэ нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйл. 27.4 “Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно”, 28 дугаар зүйлийн 28.1 “Газар эзэмших эрхийн гэрчилгээний төрөл”, 28.1.2 “төрийн байгууллагын”, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 тушаал “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 3.1.2 “төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Зөвлөмж: Байгууллагын нэр дээрх газрыг шинэчлэн бүртгүүлж, Э дугаар авч бичиг баримтжуулах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг илүү бодож олгосон	1	754.8	1	754.8								
Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газарт Э дугаар авч баримтжуулаагүй	1	-					1	-				
Дүн	2	754.8	1	754.8			1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								